

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (Эхний хагас жилийн байдлаар)**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2019 оны 54 дугаар тогтоолд тусгуулж, Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн менежментийг сайжруулах, Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжих зорилтын хүрээнд нийт 21 арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээний 2020 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон тайлангийн хавсралтыг дөрөв дүгээр хүснэгтийн дагуу боловсруулав. Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын долоо дугаар бүлэгт заасныг баримталлаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан”-г нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилт хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв. Үнэлгээний тайланг хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хурлаар арга хэмжээ тус бүрээр урьдчилан хэлэлцүүлж, гүйцэтгэлийн тайлагналтыг сайжруулах үүрэг даалгавар өгүүлснээр тайлангийн чанар дээшилж, үнэлгээнд өөрчлөлт оров. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг
2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ,
үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)**

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж үнэлгээ, %
			100	70	40	0	(-)	
- Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимтэй хөгжүүлж, бэлчээрийн - Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, жижиг, дунд үйлдвэрийг бодлогоор дэмжих	2	21	4	12	4	-	1	70.0

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2020 оны эхний хагас жилийн байдлаар 70.0 хувьтай үнэлэгдэв. Үүнд: 4 арга хэмжээ “үр дүнтэй”, 12 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 4 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн ба “үр дүнгүй” арга хэмжээ байхгүй. Цаг үеийн асуудлаас шалтгаалан нэг арга хэмжээ үнэлэх боломжгүй.

**Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн
хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)**

	Газар, хэлтэс								
	МАА ХБЗГ	ГТ ХБЗГ	ХөҮ ХБЗГ	ЖДҮҮХ ХБЗГ	ХҮҮ ХБЗГ	МГНХ	МЭЕГ	МАА + ХУХҮСХ	
Бүгд	4	6	2	1	2	3	2	1	
100%	1	-	-	-	1	2	-	-	

	70%	3	4	1	1	-	1	1	1
	40%	-	2	-	-	1	-	1	-
	0%	-	-	-	-	-	-	-	-
	Үнэлэх боломжгүй	-	-	1	-	-	-	-	-
Үнэлгээ		77.5	60.0	70.0	70.0	70.0	90.0	55.0	70.0

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Мал аж ахуйн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 5 арга хэмжээг 77.5, Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 6 арга хэмжээг 60.0, Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 1 арга хэмжээг 70.0, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны бодлого, зохицуулалтын газар 1 арга хэмжээг 70.0, Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар 2 арга хэмжээг 70.0, Малын генетик, нөөцийн хэлтэс 3 арга хэмжээг 90.0, Мал эмнэлэгийн ерөнхий газар 2 арга хэмжээг 55.0, МААХБЗГ ба Хөрс, ургамал хамгалал, үр сортын хэлтэс хамтран 1 арга хэмжээг 70 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

Дөрөв. Дүгнэлт

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 70.0 хувьтай үнэлэгдэв.

Үндсэн чиглэлийн төлөвлөгөөний сүүлийн 4 жилийн үнэлгээг харьцуулж хүснэгтээр харуулбал:

Он	Эхний хагас жилийн үнэлгээ, %			
	2017	2018	2019	2020
Үнэлгээ	41.1	55.3	51.8	70.0

Дээрх хүснэгтээс харахад 2020 оны хагас жилийн үнэлгээг өмнөх 3 жилийнхтэй харьцуулбал 26-70 хувиар өндөр үнэлгэдсэн байна.

2. Доор дурдсан зорилт арга хэмжээний хэрэгжилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай буюу “40” үнэлгээтэй дөрвөн арга хэмжээ:

3.2.2. Вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга (МЭЕГ)

4.1.1. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах. (ХҮҮХБЗГ)

4.2.2. Жимс, жимсгэнэ тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ, га (ГТХБЗГ)

4.2.3. Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин, хувиар (ГТХБЗГ)

3. “Ковид-9” цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор 4.5. Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах (ХӨҮХБЗГ) арга хэмжээ хойшлогдсон тул үнэлэх боломжгүй байв.

4. Салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт бүрэн тусгагдахгүй байна. Тухайлбал: БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төсөл, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил (нэмэлт санхүүжилт) төсөл”.

Тав. Зөвлөмж

1. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, “Бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаал, “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А-493 дугаар тушаал, “Яамны зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам батлах тухай” журам мөрдөж тайлагнаж байхыг бүх газар, хэлтэст

2. Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгдсэн арга хэмжээг хариуцсан бүтцийн нэгж гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгайлан тусгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг III улиралд багтаан гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд оруулахыг Газар тариалангийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар, Хөнгөн үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар, Хүнсний үйлдвэрийн хөгжлийн бодлого, зохицуулалтын газар болон мал эмнэлэгийн ерөнхий газарт тус тус зөвлөсүгэй.

УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН /2020 оны хагас жил/

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Нэгдсэн дүгнэлт	Зөвлөмж	Үнэлгээ
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО									
1	3.1. Малын үржил, селекцийн хүртээмж, үр дүнг дээшлүүлж, цөм сүргийн үзлэг ангилалтыг зохион байгуулан малын бүртгэл, мэдээллийн санг өргөтгөх.	1. Үзлэг, ангилалд хамрагдах малын тоо, сая толгой			1.5	Улсын төсвийн 430.0 сая төгрөг.	ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А-112 тоот тушаалаар тухайн ажлын төсвийн хуваарийг баталж орон нутагт хүргүүлсэн бөгөөд 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 04/1415 тоот албан бичгээр Сангийн яаманд эрх нээлгэх тухай албан бичгийг хүргүүлснээр санхүүжилт бүрэн орж, 21 аймгийн 99 суманд 430.0 сая төгрөгийн санхүүжилтээр үзлэг ангилалтын ажил хийгдэж эхэлсэн. Төлөвлөгөөний дагуу 41123 адуу, 16803 үхэр, 15540 тэмээ, 97050 хонь, 34500 ямаа, 21500 сарлаг, нийт 226516 толгой малд үзлэг ангилалт хийхээр төлөвлөснөөс хаврын үзлэг, ангилалтад 31824 бод, 92235 бог, нийт 124059 толгой малыг хамруулаад байна. Мал сүрэгт үзлэг ангилалт хийх арга зүйг 21 аймаг, нийслэлийн МҮА-ны дарга, мэргэжилтнүүдэд онлайнаар өгч, хаврын үзлэг ангилалтад хамрагдсан малын төрөл, тоог 7 хоног бүр орон нутгаас авч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Яамны дэргэдэх “Мал аж ахуйн салбарыг болзошгүй эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих шуурхай штаб”-ын хуралд мэдээлж ажиллав. Мөн 2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баянхонгор аймгийн Баянбулаг суманд үржүүлж буй нутгийн шилмэл 8.0 мянган хонь, Булган аймгийн Бүрэгхангай суманд үржүүлж буй мах-ноосны чиглэлийн 15.0 мянган хонь, Өмнөговь аймгийн Цогт-Овоо суманд үржүүлж буй ноолуурын чиглэлийн 6.0 мянган ямаа, Төв аймгийн Батсүмбэр суманд үржүүлж буй сүү-махны хосолмол ашиг шимт 23.0 мянган үхэр, нийт 52.0 мянган малыг үзлэг ангилалтад хамруулж, үржлийн цөм сүрэг бүрдүүлэв. Хүрсэн түвшин : Хаврын үзлэг, ангилалтаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 124059 мал, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 52000 мал нийт 176059 мал хамрагдсан байна.	1. Үржлийн малыг үзлэг ангилалтад хамруулахдаа аймаг, сум, үүлдэр, омгийн малын төрөл, тоог ямар үндэслэлээр сонгож, тогтоож байгаа талаар тайланд тусгах. 2. Төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах ажлын хүрээнд цөм сүргийн үржлийн төвийн малд хийх, үржлийн сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгч мал худалдан авах, худалдан борлуулах ажлыг чадахжуулахад гаргаж буй зөвлөмж байна уу. 3. Малын генетик нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсгийг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-145 дугаар тушаалаар “Үржлийн малд хянан магадалгаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”-ыг баталсан. Журмын хүрээнд тухайн малын үржил, селекцийн ажлын үр дүнг ажлын хэсэг орон нутагт нь явж хянан магадалгаа хийж, үр дүнг Сайдын зөвлөлд танилцуулж, Дорноговь аймгийн Дэлгэрхийн улаан ямаа, Хэнтий аймгийн Галшарын улаан ямааг тус тус "Омог"-оор баталсан. Үүлдэр, омгоор батлуулахын тулд орон нутгийн хөрөнгөөр судалгаа, шинжилгээний ажилсайн хийгддэг. 2019 онд Дэлгэрхийн 20000, 2020 онд 3500 толгойд ямаанд үзлэг ангилалт хамруулж байна. Хэнтий аймгийн Галшарын улаан омгийн ямаа 2018 онд омгоор батлагдсан, 2019 онд 11000 толгой ямаанд гүйцэтгэсэн ба 2020 онд 2500 толгойг хамруулж байна. 4.Баянхонгор аймгийн Баянбулаг сумын хонь, Дорнод, Сүхбаатар аймгийн Дорнод-Монголын улаан үхэр, Дундговь аймгийн Сайнцагаан хонь, Ховд аймгийн Мянгад, Увс, Хөвсгөл аймгийн Тэс адууны үүлдэр, омгоор батлуулах тодорхойлолтын хүрээнд ХХААХҮ-ийн сайдын 2019 оны тушаалаар хянан магадалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсэг орон нутагт ажиллаж баталгаажуулсан, 2020 онд улсын төсвөөр үзлэг ангилалтад хамруулж байгаа зорилгоо тодорхой тайланд тусгах,	70%

2		2. Малын үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжийн тооны өсөлт, хувиар		30.0	Орон нутгийн төсвийн 216.0 сая төгрөг. Төслийн 650.0 сая төгрөг.	УИХ-ын 2017 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан "Малын генетик нөөцийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийг шинээр байгуулах, үүсгэл санаачилгыг дэмжих чиглэлийг орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн. Үүний хүрээнд 2020 оны эхний хагас жилийн байдлаар Увс аймагт 3, АрХ, Бу, ӨХА, Сэ аймагт тус бүр 2, ГоА, За, Хө, Хэ аймагт тус тус 1, нийт 15 нэгж шинээр байгуулагдаж, 21 аймаг, нийслэлийн 127 сум, 2 дүүрэгт нийт 131 нэгж үйл ажиллагаа эрхэлж байна. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр Мал үржүүлэг, технологийн ажлыг орон нутгийн нэгжээр гүйцэтгүүлэх, нэгжийг багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлыг дэмжин хэрэгжүүлж байна. ХААХОУС-ийн зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ төслөөс энэ онд төсөл хэрэгжиж буй 18 сумын Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжүүдэд зоо багаж авахад зориулж 108.5 сая, МУСҮТ-д өндөр ашиг шимт донор мал авахад зориулж 541.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2020 оны А-80 дугаар тушаалаар "Цөм сүрэг худалдан авах, мал үржүүлэг, технологийн багаж, тоног төхөөрөмж, мал ангилалтын зөөврийн хашаа худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" тендерийн үнэлгээний хороо байгуулагдан, тендерийг 2020 оны 6 сарын 22-ний өдөр нээхээр хуулийн хүрээнд ажиллаж байна. Мөн төслийн хүрээнд орон нутгийн оролцооны нийт 216.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг Малын үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжүүдэд дэмжлэг болгон зарцуулахаар болов. Үүний үр дүнд АрХ, ӨвХ, ДуГ, До, Сү, Хэ аймгийн 13 мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжид зоо багаж, тоног төхөөрөмж, үржлийн мал нийлүүлэх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэж, тендерийг орон нутагт зохион байгуулж байна. АрА-т тендерийг зохион байгуулж байгуулж Эрдэнэмандал сумын "Том селекци"ХХК шалгарч 32 толгой Эделбай үүлдрийн хуцыг Цөм сүргийн үржлийн төвийн хяналтад авлаа. Хүрсэн түвшин : 15 нэгж шинээр байгуулагдаж, 21 аймаг, нийслэлийн 127 сум, 2 дүүрэгт 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 131 нэгж үйл ажиллагаа эрхэлж байна.	Улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр 21 аймгийн 99 сумын 226.5 мянган толгой малд хийгдэж буй үзлэг ангилалтын ажлыг орон нутгийн МУТАУ-ний хэдэн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байгаа вэ? 2020 оны эхний хагас жилийн байдлаар Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 30 нэгж шинээр байгуулагдсан гэсэн боловч тайланд 2018 оноос гэсэн байна. 2018 он, 2019, 2020 оны эхний хагас жилийн байдлаар шинээр байгуулагдсан тоог гаргаж, харьцуулан нэгдсэн тайланд тусгуулна уу. Үнэлгээг өсгөх боломжтой.	100%
3		3. Малын мэдээллийн нэгдсэн санд бүртгэх хээлгүүлэгч болон цөм сүргийн малын тоо, сая толгой		1.5	Франц улсын "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/	Монгол Улсад баталгаажсан 52 үүлдэр, омгийн малд цөм сүргийг бүрдүүлэх зорилгоор ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А-112 дугаар тушаалаар 21 аймгийн 99 сумын 226516 толгой малд үзлэг ангилалт хийж ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хаврын технологит ажлын хугацаанд нийт 176 059 толгой мал үзлэг ангилалтад хамрагдсанаас Малын	Улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр 21 аймгийн 99 сумын 226.5 мянган толгой малд хийгдэж буй үзлэг ангилалтын ажлыг орон нутгийн МУТАУ-ний хэдэн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байгаа вэ? 2020 оны эхний хагас жилийн байдлаар Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний 30 нэгж шинээр байгуулагдсан гэсэн боловч тайланд	100%

					туршилтын төслийн 100.0 сая, улсын төсвийн 50.0 сая төгрөг	үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийт 8.8 мянган толгой хээлтүүлэгч, 36.9 мянган толгой цөм сүргийн мал бүртгэгдсэн байгаа нь 2019 оны түвшинтэй харьцуулахад 50 хувийн үзүүлэлттэй байна. Монгол адууны үүлдэрлэг байдалд молекул биологийн судалгаа хийх, стандартыг шинэчлэн тогтоох, хурдан морины бүртгэлийн цахим программ, мэдээллийн сан бий болгох ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, нийт 1500 адуунд туршилтын чип суулгаж, цусны дээж авах ажлын гүйцэтгэл 80 хувь буюу 1200 адуунд гүйцэтгээд байна. Өвөрхангай аймагт хэрэгжиж буй "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд аймгийн ХХААГ, төсөлд сонгогдсон Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумдын ХАА-н тасаг, Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, малчдад "Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын туршилт"-ын талаарх сургалтыг 2020 оны 6 дугаар сарын 05-10-ны хооронд зохион байгууллаа. Үүний хүрээнд Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах нийт 190.0 мянган малыг бүртгэлжүүлэх ажлын туршилтыг эхлүүлэв. Үр дүнд нь нийт 5.0 мянган толгой адуунд чип суулгах, 20.0 мянган толгой хонь, ямааг өрхийн дугаараар ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах ажлыг эхлүүлж, нийт 1291 толгой малын мэдээллийг оруулаад байна. Хүрсэн түвшин : Нийт 176 059 толгой мал үзлэг ангилалтад хамрагдсанаас Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийт 8.8 мянган толгой хээлтүүлэгч, 36.9 мянган толгой цөм сүргийн мал бүртгэгдсэн байгаа нь 2019 оны түвшинтэй харьцуулахад 50 хувийн үзүүлэлттэй байна. Мөн нийт 1500 адуунд туршилтын чип суулгаж, цусны дээж авах ажлын гүйцэтгэл 80 хувь буюу 1200 адуунд гүйцэтгээд байна.	2018 оноос гэсэн байна. 2018 он, 2019, 2020 оны эхний хагас жилийн байдлаар шинээр байгуулагдсан тоог гаргаж, харьцуулан нэгдсэн тайланд тусгуулна уу. Үнэлгээг өсгөх боломжтой.	
4	3.2. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх.	1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, сая толгой /давхардсан тоогоор/		59	Улсын төсөв. Нийт 13,049.7 сая төгрөг Гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалта д нийт 4,800 сая төгрөг. Архаг халдварт өвчнөөс сэргийлэх вакцин 649,7 сая төгрөг, үйлчилгээний хөлс 2,5 тэрбум	Яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөөг МЭЭГ-ын даргын 2020 оны А/34 дүгээр тушаалаар батлуулсан. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтад нийт 11 аймаг, нийслэлийн нийт 91 сум, дүүргийн 12,3 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулсан. Бог малын мялзангаас сэргийлэх дархлаажуулалтад 3,9 сая толгой төл, хонины цэцгээс сэргийлэх дархлаажуулалтад 3,0 сая толгой төлийг 08-09-р сард хамруулахаар төлөвлөн шаардагдах вакциныг худалдан авах ажил хийгдэж байна. МЭЭГ-ын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөгөө батлуулснаар Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын төсвийн санхүүжилт бүхий 7 нэрийн вакцинд 11,0 сая, орон нутгийн төсвийн санхүүжилт бүхий 9 нэрийн вакцинд 11,7 сая, иргэн, хуулийн этгээдийн санхүүжилт бүхий 3 нэрийн вакцинд 5,0 сая, нийт 19 нэрийн өвчнөөс	Өвчний тохиолдлын мэдээллийг өмнөх оны мөн үетэй эсвэл өмнөх нэгдүгээр улиралтай нэгдүгээр улирлыг харьцуулан дүгнэж тусгах. Орон нутагт хийгдэж байгаа бусад дархлаажуулалтын мэдээллийг тусгах. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.9 дэх заалтыг зөв хэрэгжүүлэх чиглэлд анхаарч Төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтын төлөвлөгөө батлах асуудлыг зөв хэрэгжүүлэх.	70%

						<p>төгрөг Бруцеллёзын вакцин 2,4 тэрбум, үйлчилгээний хөлс 2,7 тэрбум төгрөг</p>	<p>сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 24,7 сая, Малын бруцеллёзоос сэргийлэх дархлаажуулалтын ажилд 15,4 сая толгой охин төлийг хамруулахаар төлөвлөн, вакциныг үйлдвэрлээд байна. 2020 оны хагас жилийн урьдчилсан мэдээгээр 11,9 сая толгой мал хамруулж, төлөвлөгөөний хэрэгжилт 33,5%-тай байна. Мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх вакциныг Биокombинат УТҮГ-аас орон нутагт хүргэлт 90,6%-тай байна. 2020 оны 2 дугаар улирлын урьдчилсан мэдээгээр 16,7 сая толгой мал, амьтан хамруулаад байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар 21 аймаг, нийслэлийн давхардсан тоогоор 545 суманд халдварт өвчний 1103 гаралт бүртгэгдэж, нийт 18122 мал, амьтан өвчилсөн байна. 2020 оны эхний хагас жилд галзуу 16 аймгийн 103 суманд, Боом өвчин 3 аймагт тус тус бүртгэгдсэн. Гоц халдварт өвчнөөс 2019 онд шүлхий 6, бог малын мялзан өвчин 1, хонины цэцэг өвчин 1 бүртгэгдсэн бол 2020 оны эхний хагас жилийн байдлаар эдгээр өвчнөөр тайван байна.</p> <p>Хүрсэн түвшин : Гоц халдварт өвчнөөс 2019 онд шүлхий 6, бог малын мялзан өвчин 1, хонины цэцэг өвчин 1 бүртгэгдсэн бол 2020 оны эхний хагас жилийн байдлаар эдгээр өвчнөөр тайван байна.</p>		
5		2. Вакцинжуулалтын дараах тандалт шинжилгээнд хамруулах малын тоо, мянга			200	<p>Улсын төсөв - 701.0 сая төгрөг. Орон нутгийн төсөв - 190.0 Шүлхийн вакцины дархлаа шалгах тандалтад 100,0 сая, Бруцеллёзын тандалтад 213.0 сая, оношлуур хэрэглэгдэхүүний зардалд 338.0, бог малын мялзангийн мониторингийн зардалд 50.0 сая төгрөг. Орон нутагт хэрэгжих мониторингд 190.0 төгрөг</p>	<p>Шүлхийн вакцины дархлаа шалгах тандалт судалгаанд нийт 9 аймаг, нийслэлийн 330 хот айлын 4.950 малаас цуглуулсан сорьцод лабораторийн шинжилгээ хийгдэж байна. Бог малын мялзангаас сэргийлэх вакцины дархлаа шалгах тандалтыг 10-11-р сард гүйцэтгэхээр төлөвлөсөн. Хээлтүүлэгч малд бруцеллёзын тандалт хийх гэрээг УМЭАЦГЛ-той байгуулж, нийт 213.0 сая төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн. Шаардагдах хэрэглэгдэхүүнийг нийлүүлж, 6 сарын сүүлээр эхлүүлэхээр төлөвлөж байна. Нийслэлд шүлхийн тарилга хийгдсэн 6 дүүргийн нийт 482 өрхийн 168,7 мянган толгой малыг хамруулан малчин өрхөд гүйцэтгэлийн хяналтыг газар дээр нь болон Мал эмнэлгийн нэгдсэн цахим системээр дамжуулан гүйцэтгээд байна. Нийслэлээс гадна 11 аймагт дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт хийгдэж байна. Хүрсэн түвшин: Шүлхийн тандалтаар 4,950 сорьцын лабораторийн шинжилгээ хийгдэж байна.</p>	<p>Нийт хэдэн вакцины үр дүнг вакцинжуулалтын дараах мониторингоор хэмжих талаар тусгах. Бруцеллёз бий. Дархлаажуулалт бүхий бусад өвчний дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналтын асуудлыг тусгаж байвал хүрэх түвшинд заасан 200.0 мянга хангах байх. Заавал лабораторийн шинжилгээ гэж заагаагүй байгаа тул.</p>	40%
6	3.3. “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	1. Хэрэгжилтийн явц, хувиар			30.0	<p>Хувийн хөрөнгө оруулалт: 3.0 тэрбум төгрөг.</p>	<p>Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор ЭМАА хөгжлийг дэмжих хөтөлбөрийг, 2019-2023 оны хэрэгжүүлэх төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын А-120 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2020 оны төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагаас санал авч нэгтгэн МААХБЗГ-ын даргаар батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж байна. МУЗГ-аас, Бүгд Найрамдах</p>	<p>Вакцины дараах мониторингид хамруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс гадна гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлсэн талаарх мэдээллийг бүрэн тусган тайлагнаж байх.</p>	100%

						<p>Беларусь Улсын Засгийн газар 2-ын хоорондын Экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр манай орны газар тариалангийн бүс нутагт 600 үнээ бүхий 5 сүүний эрчимжсэн цогцолбор ферм байгуулах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж, төслийн баримт бичгийг 2020 оны 2 дугаар сард зарлан энэ төсөлд оролцохоор нийт 15 аж ахуйн нэгж материалаа ирүүлснээс 5 аж ахуйн нэгжийг эхний ээлжид сонгон шалгаруулаад манай талаас хийх ажлуудыг дэс дараатай зохион байгуулж байна. Сүүний үхрийн кластрийн системийг Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд тус тус хэрэгжүүлж байна. Малын генетик нөөцийн Үндэсний зөвлөлдөх хорооны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар “Зөгийн аж ахуйд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн төслийг хэлэлцүүлээд гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдсэн тул Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлуулах дүгнэлт гаргуулав. Хүрсэн түвшин : Сүүний үхрийн кластрийн системийг Төв аймгийн Баяндэлгэр, Эрдэнэ, Баянчандмань, Борнуур, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд тус тус хэрэгжүүлж байна.</p>		
7	3.4. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүй, хариуцлагын тогтолцоо, бэлчээрийн менежментийг сайжруулах.	1. Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулсан аймгийн тооны өсөлт, хувиар		50.0	<p>Улсын төсөв: 15.0 сая төгрөг. Ногоон алт-малын эрүүл мэнд төсөл: 100.0 сая төгрөг</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох аргачлалын дагуу "Бэлчээрийн тухай" хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг тус тус боловсруулж, ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөлд хөндлөнгийн үнэлгээг НҮБ-ын ХХААБ, Бодлого судлалын төв хамтран гүйцэтгэж 11 аймагт хэлэлцүүлэг зохион байгуулсан. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2018 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Засгийн газарт "...Бэлчээрийн тухай хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлэх..." чиглэл өгсний дагуу явц, үүссэн нөхцөл байдлын талаар сайд Ч.Улаан Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж, 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд "Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг 2019 оны 4 дүгээр сард багтаан батлахыг ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж, ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан, БХБ-ын сайд Х.Баделхан нарт, хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг сайд Ч.Улаанд тус тус даалгасан. ХХААХҮЯ болон БХБЯ-ны төлөөлөл Бэлчээрийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд гарын үсэг зурж, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/1514 тоотой ХЗДХ-ийн сайдад хуулийн үзэл баримтлалын төслийг хүргүүлсэн ч 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 1-1/1882 тоот албан бичгээр тус төслийг</p>	<p>2020 оны эхний хагас жилийн байдлаар бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулсан аймгийн тооны өсөлт, талбайн хэмжээ?</p>	70%

						хамтран батлах боломжгүй гэж буцаасан. УИХ-ын Тамгын газар, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санаачилгаар “Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг Төрийн ордноо 2019.05.07-ны өдөр зохион байгуулж, 20 аймаг 316 сумын малчид, орон нутгийн удирдлагын төлөөлөл 780 хүн оролцож, 80 гаруй төлөөлөгч үг хэлж, байр сууриа илэрхийлэн, 728 оролцогч бичгээр санал өгч, зөвлөмжийн төслийг төлөөлөгчдийн олонхын саналаар баталж, УИХ, Засгийн газарт хүргүүлсэн боловч хуулийн төслийг хэлэлцээгүй байна. Хүрэн түвшин : ХХААХҮя нь олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй орон нутгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж байна.	
8	2. Бэлчээрийн менежментэд зарцуулсан хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх хувь		30.0	-	“Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслөөс 21 аймгийн 186 суманд 1362 бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулж, 2019 оны жилийн эцсийн байдлаар 11 аймгийн 830 бэлчээр ашиглагчдын хэсэг сумын ЗД-тай бэлчээр ашиглах гэрээг 15 жилийн хугацаатай байгуулж бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд АрХ, ДуГ, До, ӨвХ, СүБ, Хэ аймгийн 18 суманд 150 БАМБ байгуулж, малчдын бүлгийн бэлчээрийн менежментийн 3 жилийн төлөвлөгөөний дагуу 2019 онд Хэ-Норовлин сум 48.0 мян га-г чөлөөлж, 2020 онд Хэ-Батширээт сум 23.3 мян, Өмнөдэлгэр сум 101.5 мян, Норовлин сум 48.0 мян, ДуГ-Дэлгэрцогт сум 1.8 мян, Эрдэнэдалай сум 2.7 мян, До-Сэргэлэн сум 17273.8 мян, Халхгол сум 52074.7 мян, ӨвХ-Төгрөг сум 4.6 мян, Хархорин сум 565.2 мян, АрХ-Хайрхан сум 6.1 мя, нийт 258.1 мян га бэлчээрийн талбайг малын хөлөөс 3 сарын хугацаатай чөлөөлөхөөр төлөвлөсөн байна. Хүрэн түвшин : “Ногоон алт-Малын эрүүл мэнд” т 11 аймгийн 830 бэлчээр ашиглагчдын хэсэг сумын ЗД-тай бэлчээр ашиглах гэрээг 15 жилийн хугацаатай байгуулж бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд АрХ, До, ӨвХ, Хэ аймгийн зарим суманд нийт 258.1 мян га бэлчээрийн талбайг малын хөлөөс 3 сарын хугацаатай чөлөөлөхөөр төлөвлөсөн байна.	1.Доройтсон бэлчээрийг сэлгэн өнжөөх, бэлчээрийн хортон мэрэгчид тархсан талбайд тэмцэх ажлыг хичнээн га талбайд (Санхүүгийн эх үүсвэр, хэмжээг) зохион байгуулсан? 2.Усан хангамж хүрэлцээгүй хэдэн аймгийн бэлчээрт хичнээн гар худаг болон хичнээн инженерийн хийцтэй худаг гаргах? гүйцэтгэл ямар хувьтай байгааг тайланд доторхой тусгах, 3.Хур борооны ус цуглуулах хөв цөөрөм байгуулах ажлыг хэдэн аймгийн хэдэн цэг төлөвлөж, гүйцэтгэл ямар хувьтай байгаа талаар тодорхой тайланд тусгах. 4.Доройтолд орсон 4.9 сая га бэлчээрийг сэлгэн өнжөөж сайжруулах, бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготготой энгийн механик аргаар 17 аймаг, аймаг дундын отрын бүс нутагт 1,16 сая га, микробиологийн аргаар 8 аймгийн 285 мян га талбайд, царцаатай тэмцэх ажлыг 3 аймгийн 66,0 мян га талбайд нийт 5,0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж буй ажлын гүйцэтгэл, орон нутгийн болон төсөл хөтөлбөрийн хүрээнд хийж байгаа ажлын гүйцэтгэлийг тус тус дахин тайлагнаж нэгдсэн тайланд бүрэн тусгах. Үнэлгээг өсгөх боломжтой.	70%
9	3. Тэмцсэн бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээ, талбайн		1	Улсын төсөв: 4.6 тэр бум Орон орон нутгийн төсвөөс 971 сая төгрөг бэлдмэл өгсөн.	ХХААХҮ-ийн сайдын А-89 дүгээр тушаалын хүрээнд бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээг 2020 онд 1.3 сая га талбайд улсын төсвийн 5.0 тэрбум төгрөгөөр тэмцэх ажлыг зохион байгуулж байна. Үлийн цагаан оготготой Аймаг дундын отрын бүс нутгийн 66.3 мян га, 17 аймгийн 159 сумын 1.016 сая га бэлчээрт энгийн механик аргаар тэмцэхэд улсын төсвийн 1.8 тэрбум төгрөг, 8 аймгийн 34 сумын 285.0 мянга га бэлчээрт микро биологийн аргаар тэмцэхэд 2.8 тэрбум төгрөгийг зарцуулж, тайланг нэгтгэж	Ажлын хүрээнд эхний хагас жилийн байдлаар хийсэн ажлыг тайлагнаж, нэгдсэн тайланд тусгах.	70%

		хэмжээ, сая.га				байна. 3 аймгийн 66.0 мянган га талбайд царцаатай тэмцэх ажлын тодотгох сулгаанд орон нутгийн төсвөөс 971 сая төгрөг зарцуулан хийж, тэмцэх ажлын бэлтгэл хангав. Үлийн цагаан оготнын бэлчээрт учруулах хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд 2019 онд улсын төсвийн 3.1 тэрбум, орон нутгийн төсвийн 570 сая, нийт 3.7 тэрбум төгрөг зарцуулж 1.3 сая га бэлчээрийн талбай, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 4.6 тэрбум төгрөгөөр 1.3 сая га талбайд тэмцэж байна. Өмнөх оны төвшинтэй харьцуулахад 0.9 тэр бум төгрөг илүү зарцуулсан байгаа нь микробиологийн аргаар тэмцэж байгаа талбайн хэмжээ их байна. Хүрсэн түвшин : Үлийн цагаан огтонотой Аймаг дундын отрын бүс нутгийн 66.3 мян.га, 17 аймгийн 159 сумын 1.016 сая.га бэлчээрт энгийн механик аргаар тэмцэхэд улсын төсвийн 1.8 тэрбум төг, 8 аймгийн 34 сумын 285.0 мян.га бэлчээрт микробиологийн аргаар тэмцэхэд 2.8 тэрбум төгрөгийг зарцуулж, тайланг нэгтгэж байна.	
10	4.1. “Эрүүл хүнс – Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Мах, сүүний анхдугаар аян”-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах.	1. Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар		40.0	Жилийн эцсээр нийт зарцуулсан мөнгөний тайлан гарна.	1/Нийслэл, 21 аймгийн Засаг даргын төлөвлөгөөнд "Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх заалт туссан. 2/Хүн амын хүнсний шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, зохистой хооллох дадлыг төлөвшүүлэх зорилгоор "Өглөөний цай" болон "Эжийн сонголт-Эрүүл хүнс" хөдөлгөөний хэлэлцүүлгийг 2020.01.10-нд Төрийн ордонд зохион байгуулав. Хөдөлгөөнүүдийн шторкыг гүйцэтгүүлж олон нийтэд хүргэв /Хавсралт/ 3/Хүнсний аюулгүй байдал алдагдах үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж ХХААХҮ-ийн Сайдын зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдэв. Тус төлөвлөгөөг ХАБҮЗ-д хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Төлөвлөгөөг хавсаргав. 4/"Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн" үндэсний хөтөлбөрийн 3.5.7-д заасны дагуу хүнсний инженерчлэл мэргэжлийн чиглэл Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалтад багтсан. 5/Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор "ЖДҮХС-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих" журмыг шинэчлэн баталсантай холбогдуулан тэргүүн ээлжинд дэмжих салбар, чиглэлийн жагсаалтад хүнсний тэргүүлэх салбар, чиглэлийг оруулах саналыг хүргүүлж тусгуулсан. 6/Мал төхөөрөх үйлдвэрлэлийг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр зохицуулах бодлогын санал, үндэслэл, тайлбарыг бэлтгэж, Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар УИХ-ын холбогдох ажлын хэсэгт хүргүүлсэн. 7/УБ хотын хүн амын 2020 оны хаврын улирлын хэрэгцээнд нөөцийн мах хөнгөлөлттэй үнээр худалдах ажлыг зохион байгуулж, 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 7747.0 тн махыг нийлүүлээд байна. 8/Вьетнам улс КОВИД-той холбогдуулан цагаан будааны экспортдоо квот	40%

						тогтоосон тул тус улсын ЭСЯ-тай уулзаж, МУ-н импортыг үргэлжлүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэнх, Хэрэгжүүлсэн ажлын тайланг хавсралтаар хүргүүлэв.		
11		2. Нөөцийн махны хэмжээ, мянган.тонн		10.0	3600	Дотоодын махны хангамжийг тогтворжуулах зорилтын хүрээнд Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан Засгийн газрын 2019 оны 285, 329 дүгээр тогтоолын дагуу арилжааны банкны эх үүсвэрээр болон экспортлосон махны 10 хувьтай тэнцэх тоо хэмжээний махыг нийлүүлэх бодлогын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн, нийт 12.0 мянган тн махыг дотоодын зах зээлд нийлүүлэхээр бэлтгэсэн. Бэлтгэж, нөөцөлсөн махыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлсэн. Нөөцийн махыг Нийслэлийн 9 дүүргийн 169 хорооны хүнсний 413 дэлгүүрээр дамжуулан хонины ястай мах 6700 төг/кг, үхрийн ястай мах 7700 төг/кг, ямааны мах 6200 төг/кг үнээр худалдаалж байна. Нөөцийн махны худалдаагаар 2020 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар нийт 7951.6 тн махыг нийлүүлээд байна. Үүнээс: үхрийн ястай мах 2038.3 тн, хонины ястай мах 5005.6 тн, ямааны ястай мах 907.3 тн. Хүрсэн түвшин : Нийслэлийн хүн амын хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан арилжааны банкны эх үүсвэрээр болон экспортлосон махны 10 хувьтай тэнцэх тоо хэмжээний махыг нийлүүлэх бодлогын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн, нийт 12.0 мянган тн махыг дотоодын зах зээлд нийлүүлж, махны хангамжийг тогтворжуулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.		100%
12	4.2. Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангалтыг нэмэгдүүлэх.	1. Хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх хувь		5.0	Улсын төсөв 160.0 сая төгрөг, НҮБ-ын ХХАА-н байгууллагаас 100 сая төгрөг.	Улсын хэмжээнд 2020 онд 9.2 мянга га-д тариалалт хийхээр төлөвлөсөн. Улсын төсвийн 160.0 сая төгрөгт ил талбайн болон хүлэмжийн хүнсний ногооны үрийн хуваарь батлах тухай А-171 дугаар тушаал батлуулж 2020 онд тендер худалдан авалтаар хүлээн авсан 11 нэр төрлийн нийт 5082,6 кг үрийг 21 аймаг, нийслэлийн дүргүүдэд баталсан хуваарийн дагуу буцалтгүй дэмжлэгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Ковид цар тахалтай холбоотойгоор төмс, хүнсний ногоо нэмж тариалах, хангамж нэмэгдүүлэх зорилгоор НҮБ-ын ХХАА-н байгууллагад хүсэлт тавьснаар 100 сая төгрөгт шар лууван1300 кг, шар манжин 500 кг, хүрэн манжин 330 кг, төл сонгино 1 тн, саримс 42 кг, урт сонгины үр 200 кг, хүлэмжийн хэмх 1 кг, лооль 0,9 кг, чинжүү 12 кг үр авч 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ногоочдод дэмжлэгээр олгов. Хүрсэн түвшин : 06 сарын 12-ны байдлаар 7.5 мянган га буюу тариалалт 81.6 хувьтай байна.ноднингийн мөн үеэс 15 хувиар илүү тариалалттай байна. 70%		70%
13		2. Жимс, жимсгэнэ тариалах шинээр нэмэгдэх талбайн хэмжээ,		8000	Улсын төсөв-100.0 сая төгрөг, ОУБ-40.0 мянган ам.доллар.	1. Сүхбаатар, Говь-алтай аймагт суулгац үржүүлгийн төв байгуулах тендер шалгаруулалт зохион байгуулж байна. 2. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд ХААИС-ийн харьяа Борнуур дахь туршилт		40%

		га				<p>судалгааны төвд “Жимс жимсгэний сортуудын туршилт судалгаа хийх, жимс жимсгэний генофонд байгуулах” гэрээ байгуулав. 3. Улсын төсвийн 147.4 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилтээр суулгац үржүүлэх дэвшилтэт технологийн мананжуулагч бүхий 120 м2 талбай бүхий 10 иж бүрдэл нийлэг хальсан хүлэмж нийлүүлж ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А-78 дугаар тушаал гарган суулгац үржүүлэх иргэн аж ахуйн нэгжид 30 хувийн урьдчилгаатай 4 жилийн хүүгүй зээлээр олгож эхлэв. Үүний үр дүнд суулгац үйлдвэрлэл 200.0 мянган ширхэгээр нэмэгдэх боломж бүрдүүлэв. 4. 2020 оны хавар чацарганы 10.4 мянган ширхэг суулгацыг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож тариалуулав. 5. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд “Чацаргана жимс жимсгэний талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулах стандарт боловсруулах”, “Жимс жимсгэний талбайд сортын хянан баталгаа хийх арга зүй техникийн шаардлага” стандарт боловсруулж батлуулах гэрээг 2 байгууллагатай байгуулж ажлыг эхлүүлэв. 7. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй “Монголын худалдааг дэмжих” TRAM төслийн хүрээнд “Чацарганын кластер байгуулах” төсөл хэрэгжүүлж чацарганын кластерт оролцогчдыг бүртгэлжүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ажиллаж байна. 2020 оны 1 дүгээр сард Герман улсад зохиогдсон Green week хүнсний бүтээгдэхүүний олон улсын үзэсгэлэнд тус төслөөс 11.0 мянган еврогийн санхүүжилт зардал гарган стэнд түрээсэлж чацарганы боловсруулах 4 үйлдвэрийн бүтээгдэхүүнийг сурталчлав. Хүрсэн түвшин : Жимс жимсгэний тариалалт 2020 оны хавар 6600 га талбайд хүрэв.</p>	
14	3. Хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтын түвшин, хувиар			60.0	12 сая төгрөг 900,0 мянган ам доллар	<p>Хүн амын эрүүл, аюулгүй төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангалт, үйлдвэрлэлийн механикжилтийн төвшинг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2020 онд Техник дундын үйлчилгээний техникийн шинэчлэл хийх зориулалтаар улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 112.0 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний ногооны иж бүрдэл техникийг Орхон аймгийн ХХААГ-т зээлээр олгосон. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020.05.01-ний өдрийн А-145 дугаар тушаалаар БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн нийт 1.8 сая ам. долларын үнэ бүхий 50-90 м.х-тэй 84 ширхэг трактор, 37 ширхэг бууц, бордоо цацагчийн үнийг 50 хувь хөнгөлөн газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, иргэдэд 20 хувийн урьдчилгаатай 2 жилийн хугацаатай жилийн 6 хувийн хүүтэй зээлээр олгосон. Хүрсэн түвшин : 2020 оны байдлаар төмсний үйлдвэрлэлийн механикжуулалт 65%, хүнсний ногоо үйлдвэрлэлийн механикжуулалт 45%-тай байна</p>	40%

15	4.3. Үр тарианы талбайн хөрсний үржил шимийг сайжруулж, ургацын хэмжээг нэмэгдүүлэх, Атрын IV аяныг эхлүүлэх.	1. Хураан авах үр тарианы хэмжээ, мянган.тонн		400	Улаанбуудайн 5.0 мянган тонн үр импортоор авахад Улсын төсвөөс 5.0 тэрбум төгрөг зарцуулсан болно.	2019 оны ургац хураалтын дүнгээр нийтдээ 424.4 мянган тонн үр тариа, үүнээс 407.6 мянган тонн улаанбуудай, 119.6 мянган тонн тэжээлийн ургамал тус тус хураан авч, гурил үйлдвэрлэлд 247.8 мянган тонн буудай нийлүүлэгдсэн болно. Тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэд 354.8 мянган га-д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэсний 192.1 мянган га талбайг нь дэвшилтэт технологиор боловсруулсан байна. 2020 онд улсын хэмжээгээр 384.2 мянган га-д үр тариа, үүнээс 356.8 мянган га-д улаанбуудай, 38.2 мянган га-д малын тэжээл, 41.0 мянган га-д тосны ургамал тариалах зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Тариалалтад зориулан аж ахуйн нэгж, иргэд 33.0 мянган тонн, Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Онцгой байдлын ерөнхий газарт 7.5 мянган тонн, нийтдээ дотоодоосоо 40.5 мянган тонн үрийн буудайн нөөц бүрдүүлж импортоор 5.7 мянган тонн үр нийлүүлснээр төлөвлөсөн талбайдаа тарих боломжийг бүрдүүлэв. Тариаланчдад учрах санхүүгийн дарамтыг багасгах, тариалалтыг технологийн хугацаанд чанар сайтай зохион байгуулах зорилгоор ХААДС-аар дамжуулан 245 аж ахуйн нэгж, иргэнд 1.2 мянган тонн шатахууныг 50 хувийн, 332 аж ахуйн нэгж, иргэнд 12.2 мянган тонн үрийн буудайг 30 хувийн урьдчилгаатайгаар олгож дэмжлэг үзүүлэв. Хүрсэн түвшин : 06 дугаар сарын 02-ний байдлаар улсын хэмжээгээр 320.9 мянган га-д үр тариа, үүнээс 313.2 мянган га-д улаанбуудай, 13.0 мянган га-д төмс, 5.1 мянган га-д хүнсний ногоо, 7.2 мянган га-д малын тэжээл, 16.3 мянган га-д тосны ургамал, нийтдээ 363.0 мянган га-д тариалалт хийгээд байгаа бөгөөд үр тарианы тариалалт 87,8 хувьтай, тэжээлийн болон бусад үр тарианы тариалалт эрчимтэй явагдаж байна.		70%
16		2. Усалгаатай талбайн хэмжээ, мянган га		50 хүртэл	4700 сая төгрөг	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх" төслийн хүрээнд Баян-Өлгий, Орхон, Төв, Хэнтий, Сэлэнгэ, Увс, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай, Архангай аймгуудад 3514 га талбайг услах хүчин чадал бүхий үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримал тариалах зориулалт бүхий усалалтын системийн зураг төсөл, хийгдсэн. Шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдийн төслийг Хөдөө аж ахуйг дэмжих санд зохих журмын дагуу олгох тухай албан тоотын хамт хүргүүлж 2839 га талбайд усалгааны тоног төхөөрөмжийг суурилуулаад байна. Хүрсэн түвшин : 2839 га талбайд усалгааны тоног төхөөрөмжийг суурилуулаад байна.	Хүрсэн түвшинг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнана уу.	70%
17		3. Аяны бэлтгэлийг хангах ажлын явц, хувиар		100.0	Улсын төсвийн 6.0 тэрбум төгрөг. Гадаадын зээлийн 10.0 сая ам. доллар	Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020.01.09-ний өдрийн 05 дугаар захирамжаар Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Зөвлөлийг байгуулсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020.03.27-ны өдрийн А-118 дугаар тушаалаар "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-		70%

						г батлан хэрэгжилтийг зохион байгуулж байна. Тус тушаалаар “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг өөрийн орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсөн. Мөн Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлүүлэх, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг удирдлага зохион байгуулалтаар хангаж хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосон. Хүрэн түвшин : 100%			
18	4.4. Жижиг, дунд үйлдвэр болон загвар хоршоодыг санхүү, зээлийн бодлогоор дэмжих.	1. Ажлын байрын тооны өсөлт, хувиар			20.0	-	Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг хэлэлцэн батлав. Журмын хүрээнд 2020.04.20-05.20 өдрүүдэд сонгон шалгаруулалтанд оролцох төслийг бүртгэн хүлээн авсан. Сангийн зээлийн мэдээллийн нэгдсэн системд нийт 1,576 төсөл хэрэгжүүлэгчийн 238.5 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт бүртгэгдсэн байна. ЖДҮХС-д 159,7 тэрбум төгрөгийн 769 төсөл, орон нутагт – 78,8 тэрбум төгрөгийн 807 төсөл хүлээн авлаа. Төслийн сонгон шалгаруулалт явагдаж байна. Хүрэн түвшин : -		70%
19	4.5. Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах.	1. Экспортын боловсруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, хувиар			2.0-оос доошгүй	-	(Covid -19) халдвар олон улсад тархаж цар тахлын хэмжээнд хүрсэн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоо Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажил хойшлогдоод байна. Ажлыг хоёрдугаар хагас жилд гүйцэтгэхээр төлөвлөж байна.	Ковид-9 цар тахалтай холбоотойгоор хойшлогдсон тул үнэлэх боломжгүй.	Үнэлэх боломжгүй
20	4.6. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	1. Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар			21 аймагт үйлдвэр байгуулах	ЖДҮХС-аас 3.5 тэрбум төгрөг, Улсын төсвөөс 20 тэрбум төгрөг, Хөгжлийн банкаас 21 тэрбум төгрөг, ОНХС-аас 1.2 тэрбум төгрөг, Гадны хөрөнгө оруулалтаар 161	ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоолоор батласан “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд Бүтээн байгуулалтын ажил 100 хувь хийгдэж шинээр бүрэн ашиглалтад орсон 42 үйлдвэр, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа 19 үйлдвэр, хөтөлбөрийн 5.4-т “Хөтөлбөр хэрэгжих явцад улсын болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын орчин зэргээс шалтгаалан үр ашиг, ач холбогдол бүхий шинээр байгуулсан үйлдвэрийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих үйлдвэрийн тоонд тооцож болно” гэж заасны дагуу ЖДҮХС, Улсын төсөв, ОНХС, гадны хөрөнгө оруулалтаар 11 үйлдвэр, нийт 72 үйлдвэр		70%

						тэрбум төгрөг, Хувийн хэвшлээс 73 тэрбум төгрөг, Бусад хөрөнгө хөрөнгө оруулалтаар 4.2 тэрбум төгрөг	2018-2019 онд байгуулагдсан байна. Тус 72 үйлдвэрийг задлан харуулбал: УБ хотод 5, орон нутагт 67 үйлдвэр /2017 онд 2, 2018 онд 22, 2019 онд 48 / шинээр болон үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна. Хөтөлбөрийн хүрээнд ЖДҮХС-аас 3.5 тэрбум төгрөг, Улсын төсвөөс 20 тэрбум төгрөг, Хөгжлийн банкнаас 21 тэрбум төгрөг, ОНХС-аас 1.2 тэрбум төгрөг, Гадны хөрөнгө оруулалтаар 161 тэрбум төгрөг, Хувийн хэвшлээс 73 тэрбум төгрөг, Бусад хөрөнгө оруулалтаар 4.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийт 72 үйлдвэр шинээр болон үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Хөтөлбөрийн үр дүнд: Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 2020 оны хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувь, арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 40 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 25.2 хувь, шинээр 72 үйлдвэр байгуулагдаж 4000 орчим ажлын байр бий болсон байна. Хүрсэн түвшин : УБ хотод 5, 21 аймагт 67 үйлдвэр байгуулагдсан.		
ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛДОГО									
21	9.3. Биологийн олон янз байдлын тухай болон цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах.	1. Биологийн олон янз байдалд чухал ач холбогдол бүхий газруудад хамгааллын болон доройтлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний тоо			2-оос доошгүй	ГТХБЗГ: 24,0 сая төгрөг	БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж буй Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төслийн хүрээнд Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг сайжруулах газрын доройтлыг бууруулах зорилгоор бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэн (зэрлэг амьдын бэлчээрийн асуудлыг тусгах) За-Бэлчээр ашиглах үлгэрчилсэн журам боловсруулж сумын ИТХ-аар батлав. Үлдсэн 3 (Ар, БХА, ГоА) аймгийн журмын төсөлд санал авч байна. Бэлчээр хариуцлагдажуулах журмыг зорилтот 13 сумаас БНА-ийн 2 сум (Баянцагаан, Шинэжинст), ГоА-ийн 1 сум (Чандмань) хэлэлцүүлэн батлуулж улсын бүртгэлд бүртгүүлсэн. ГоА-Цогт, Эрдэнэ сумын журмын төсөл батлуулахад бэлэн болсон. Үлдсэн Ар 4, БНА 2, За 2 сумын журмын төслийг боловсруулав. Журам батлагдсан аймаг, сумын төсөл хэрэгжүүлж буй нутагт малчдын оролцоотой бэлчээрийн дундын сан байгуулж, эрх зүйн харилцааг зохицуулах нөхцөл бүрдэв. Хамгаалалттай бэлчээр, ойн сан, ойн зах, зэрлэг амьтдын бэлчээрийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулав. Газрын тухай хуулийн төсөлд тусгах саналыг нэгтгэн салбар дундын хэлэлцүүлэгт бэлэн болгов. Бэлчээр ашиглах журмын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах багц санал боловсруулав. ГТ-н үйлдвэрлэл эрхлэхийн зэрэгцээгээр байгалийн унаган төрх болон биологийн олон янз байдлыг хадгалах зорилгоор хөрсний үржил шимийг хамгаалах, усыг хэмнэлттэй зарцуулах, химийн бодисын зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор ГТ-н үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэв. Орон нутгийн	БОАЖЯ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагааг тайланд нэмж тусгах. Үнэлгээг өсгөх боломжтой.	70%

						<p>агрономичид, МХГ-ын байцаагчдад цахим сургалт зохион байгуулсан. ХХААХҮЯ-аас Тариалангийн талбайн хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх экологич арга, туршлага нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний ажлыг УГТХ-тэй гэрээ байгуулж, хэрэгжүүлж байна. Биологийн олон янз байдлыг хадгалахад шаардлагатай хөрсний үржил шим, чийг хамгаалахад ногоон бордуурт уринш, нөмрөг таримлын нөлөөллийг судалж, заавар боловсруулна.</p> <p>Хүрсэн түвшин : Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг сайжруулах газрын доройтлыг бууруулах зорилгоор бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэн (ээрлэг амьдын бэлчээрийн асуудлыг тусгах) “Бэлчээр хариуцлагажуулах журам”-ыг Баянхонгор аймгийн 2 сум (Баянцагаан, Шинэжинст), Говь-Алтай аймгийн 1 сум (Чандмань) хэлэлцүүлэн батлуулж улсын бүртгэлд бүртгүүлэв Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт зохион байгуулж ШУ-ны үндэслэлтэй заавар боловсруулах ажлыг эхлүүлээд байна.</p>			
									70%